

“ШИВЭЭ-ОВОО” ХК-ИЙН 2018 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫН ТАЙЛАН

№	Хийх ажил	Хугацаа	Хэрэгжүүлэх арга хэлбэр	Хариуцах нэгж, албан тушаалтан
1.	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд	2018 оны 2, 4-р улирал	1.1. Уурхайн ажилчдад шинэчлэгдэн гарсан Эрүүгийн хууль, Зөрчлийн хууль, гэх мэт шинэчлэгдэн гарсан хуулийн талаар мэдээлэл, сургалт явуулах	<p>2018 оны жилийн эцсийн байдлаар тус компанийн хэлтэс, алба, хэсгүүдийн хууль эрх зүйн буланд шинээр батлагдсан Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Эрүүгийн хууль, Авилгын эсрэг хуулийг байрлуулж хууль сурталчилсан.</p> <p>Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн хэлтсээс зохион байгуулдаг дотоод сургалтаар Зөрчлийн тухай хуулийг сурталчлах ажлыг хийсэн. Мөн уг сургалтаар галын аюулгүй байдал болон Хөдөлмөрийн аюулгүй байдлын хууль тогтоомжийг сурталчилсан болно.</p> <p>2018 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр Говьсүмбэр аймгийн Хууль зүйн хэлтсийн дарга Д.Магвансүрэн, Хөгжлийн бодлогын хэлтсийн дарга Б.Бат-Эрдэнэ, Говьсүмбар аймаг дахь Авилгатай тэмцэх газрын дэргэдэх Олон нийтийн дэд зөвлөлийн гишүүн Д.Зандаръяа нараар “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай” хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасан “Албан тушаалтан захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцохын өмнө тус бүр ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргана” гэсэн сэдвийн хүрээнд “Шивээ-Овоо” ХК-ийн эрх бүхий албан тушаалтнууд, тус компанийн Гүйцэтгэх захирлын 2018.01.18-ны өдрийн А/08 дугаар “Тендерийн үнэлгээний хороо байгуулах тухай” тушаалын дагуу томилогдсон үнэлгээний хорооны гишүүдэд сургалт зохион байгуулсан байна.</p> <p>2018 оны 06 дугаар сарын 07, 08-ны өдрүүдэд болсон ажилчдын хурал дээр “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай” хууль, “Архидан согтуурахтай тэмцэх хууль”-ийг сурталчилж хуулийн талаарх мэдлэг олгосон.</p> <p>2018 оны 06 дугаар сарын 29-ний өдөр Говьсүмбэр аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөл болон Говьсүмбэр аймгийн Прокурорын газраас хамтран зохион байгуулсан “Эрүүгийн хуулийн тусгай ангийн 10 дугаар бүлэг Хүний амьд явах эрхийг эсрэг гэмт хэрэг, 11 бүлэг Хүний эрүүл мэнд халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, 16-р бүлэг Хүүхдийн эсрэг гэмт хэрэг, 17-р бүлэг өмчлөх эрхийг эсрэг гэмт</p>

				<p>хэрэг гэх мэт” “Зөрчлийн тухай хууль” “Захиргааны Ерөнхий хууль” сонсох ажиллагаа, “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай” хуулийн хүрээнд мэдлэг олгох сургалтанд тус компанийн ажилчдыг хамруулж дээрх хуулиарх эрх зүйн мэдлэгийг олгон ажиллаа.</p> <p>2018 оны 05 дугаар сарын 28-ны өдөр аймгийн Онцгой байдлын газартай, Гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн уурхайн орон тооны бус алба хамтран, "Гамшгийн үед хүч хэрэгсэл дайчлан гаргах журам", "Гамшгийн үеийн бэлэн байдлыг хангуулах" талаар танхимын болон үзүүлэх дадлага сургуулилтыг зохион байгуулж ажилчдад Гамшгийн үед ажиллах хууль эрх зүйн мэдлэг олголоо.</p> <p>Гэр бүл, сэтгэл судлалын ухааны доктор Г.Наранбаатарыг урьж 2018 оны 06 дугаар сарын 19-ний өдөр нийт ажилчдад “Өөртөө итгэлтэй амьдрал, өөртөө амьдралын гайхамшиг бай” сургалт зохион байгууллаа.</p> <p>Уг сургалтаар ажилчдад гэр бүлийн дотоод орчин, эвсэг байдал, хүчирхийлэлгүй гэр бүл байх, харилцан ойлголцол, өөрийгөө даван дийлэх талаарх гэр бүлийн суурь ойлголтын мэдлэгийг олгосон болно.</p> <p>Говьсүмбэр аймгийн Прокурорын газар, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний комиссын Говьсүмбэр аймаг дахь төлөөлөгчийн газартай тус тус хамтарч 2018 оны 11, 12 дүгээр саруудад нийт ажилчдад Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/ албан тушаалын гэмт хэрэг, авилгын эсрэг хууль, хөрөнгө орлогын мэдүүлэг, хөдөлмөрийн аюулгүй байдлын тухай ойлголт анхаарах асуудал, Зөрчлийн тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлийн тухай хууль, Хүний эрхийн Үндэсний комисс түүний үйл ажиллагаа, Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, хүчирхийлэл түүний үндсэн шинж, Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрэм /шинэчилсэн найруулга/ гэсэн сэдвүүдээр үргэлжилсэн 3 хоногийг сургалтыг зохион байгуулж ажиллалаа.</p> <p>ХАБЭА-н сарын аянаар эмнэлгийн анхны тусламж үзүүлэх, мэргэжлээс шалтгаалах өвчлөл, үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлэх сэдвээр нийт ажилтнуудад ажлын байран дээр нь ээлжийн эмч нараар сургалт зохион байгуулсан.</p>
		Тухай бүр	1.2. Шинээр ажилд орсон ажилтнуудад явуулах сургалтын хөтөлбөрт ГХУС хууль эрх зүйн асуудлыг тусгаж хэрэгжүүлэх, авилга, гэмт хэрэг зөрчил, архидан согтуурахаас урьдчилан	Шинээр ажилд орсон ажилтнуудад “Шивээ-Овоо” ХК-ийн Гүйцэтгэх захирлын 2015 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн А/30 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Авлига, гэмт хэрэг зөрчил, архидан согтуурахаас урьдчилан сэргийлэх заавар”-ыг тус компанийн хуулийн зөвлөх танилцуулан ажиллаж байна. 2018 оны эхний хагас жилийн байдлаар нийт 122 ажилтанд тус зааврыг танилцуулж ажилласан байна.

		сэргийлэх заавартай танилцуулж байх	
2018 ондоо	1.3. Уурхайн төв оффист дохиолол, камерын хяналтын систем суурилуулах, хяналтыг сайжруулах, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх	Уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагааны хяналтыг сайжруулах учирч болох гэмт хэрэг, зөрчилөөс эрсдэлээс урьдчилан сэргийлэх, ажилтнуудын ажлын бүтээлийг дээшлүүлэх зорилгоор уурхайн үйлдвэрлэлийн бүсэд хяналтын камерын системийг 2018 оны 12 дугаар сард бүрэн нэвтрүүлээд байна. Уурхайн үйлдвэрлэлийн бүсийг камерын системтэй болгосноор ажилтнуудын эрүүл аюулгүй орчинд ажиллах, зөрчил дутагдлыг нэг даруй илрүүлэх, хөдөлмөр зохион байгуулалтыг сайжруулах, сахилга батыг дээшлүүлэх, ажлын байранд гарч болзошгүй гэмт хэрэг, зөрчлийг таслан зогсооход чиглэсэн томоохон ажил болсон болно. Компанийн Говьсүмбэр аймгийн Шивээговь сумын 1-р багт байрлах төв оффиссын байрыг камерын хяналтын системд холбох ажил уурхайн үйлдвэрлэлийн бүсийг камерын хяналтын систем суурилуулах ажлаас шалтгаалан түр хойшилсон болно.	
2018 ондоо	1.4. Ажилчид, алба, хэсгийн саналыг авч гэмт хэргийн хор хөнөөл, хариуцлага, ял шийтгэлийн талаарх мэдээллийг мэргэжлийн байгууллагын эрх бүхий албан хаагчдыг урьж мэдээлэл авах	2018 оны жилийн эцсийн байдлаар ажилтнуудад нийт 3 удаагийн сургалтаар гэмт хэрэг зөрчил, түүний хор хөнөөл, хариуцлага, ял шийтгэлийн талаар эрх бүхий хууль, хяналтын байгууллагын албан тушаалтнуудыг авчирч лекц, ярилцлага байдлаар зохион байгууллаа. Сургалтуудыг дурьдвал Говьсүмбэр аймгийн Цагдаагийн хэлтэстэй хамтарч архидан согтуурах гэмт хэрэг түүний хор хөнөөл сэвдээр, Гэр бүл, сэтгэл судлалын ухааны доктор Г.Наранбаатарыг урьж гэр бүл түүний үндсэн шинж, гэр бүлийн хүчирхийллийн сөрөг нөлөө, урьдчилан сэргийлэх сэдвээр, Говьсүмбэр аймгийн Прокурорын газартай хамтарч гэр бүлийн хүчирхийллийн тухай хууль, хүүхдийн хүчирхийлэл түүнээс урьдчилан сэргийлэх, Эрүүгийн хууль тусгай ангийн албан тушаалын гэмт хэрэг, “Эрүүгийн хуулийн тусгай ангийн 10 дугаар бүлэг Хүний амьд явах эрхийг эсрэг гэмт хэрэг, 11 бүлэг Хүний эрүүл мэнд халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, 16-р бүлэг Хүүхдийн эсрэг гэмт хэрэг, 17-р бүлэг өмчлөх эрхийг эсрэг гэмт хэрэг гэх мэт сэдвүүдээр сургалтууд ажилтнуудад оруулж мэдээллээр хангаж ажиллалаа.	
Улирал тутамд	1.5. Шаардлагатай гэж үзвэл удаа дараа сахилгын шийтгэлд холбогдож байгаа ажилчид, удаа дараа архи	Говьсүмбэр аймгийн Шивээговь сумын Цагдаагийн тасагтай хамтарч “Архидан согтуурч нийгмийн хэв журам зөрчсөн, зөрчсөний улмаас цагдаагийн байгууллагаас эрүүлжүүлэгдсэн болон орон байрандаа архидан согтуурч олон нийтийн амгалан тайван байдал алдагдуулсан ажилчдын нэрс”-ийн жагсаалтыг гаргасан бөгөөд дээрх ажилчдад	

		уусан ажилчдад мэргэжлийн сэтгэл зүйчтэй уулзуулж сэтгэл засах сургалт хийх	Говьсүмбэр аймгийн Цагдаагийн хэлтэстэй хамтран “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль” “Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль” “Эрүүгийн хууль”-ийг сурталчлан таниулах талаар сургалт тусгайлан 2018.06.20-ны өдөр зохион байгууллаа. “Сэтгэлийн өнгө” гэр бүл, сэтгэл судлалын төвийн тэргүүн “Гэр бүл, сэтгэл судлалын ухааны доктор” Г.Наранбаатараар 2018 оны 06 дугаар сарын 19-ний өдөр нийт ажилчдад “Өөртөө итгэлтэй амьдрал, өөртөө амьдралын гайхамшиг бай” сэдвийн хүрээнд гэр бүлийн харилцан ойлголцол, хүчирхийллийн үндсэн ойлголт, түүнийг даван гарах арга замын талаарх сургалт зохион байгуулсан болно.
	2018 оны нийтээр амрах баяр болон тэмдэглэлт өдрүүдэд	1.6.Хөдөлгөөнт эргүүлийн ажлыг зохион байгуулах график төлөвлөгөө гаргаж, батлагдсан төлөвлөгөө, графикайн дагуу ажиллахыг хэлтэс, алба, хэсгийн дарга нарт тараах.	2018 оны “Хөдөлгөөнт эргүүлийн ажлыг зохион байгуулах” график төлөвлөгөө гаргаж, хэлтэс, алба, хэсгийн дарга нарт тараан өгсөн болно.
	Тухай бүр	1.7. Хөдөлгөөнт эргүүлийн ажлыг хувиарын дагуу хийж гүйцэтгэсэн хэлтэс, алба, хэсгүүд тухай бүр илтгэх хуудсаар холбогдох албан тушаалтанд мэдээлж байх.	Тус компанийн хэлтэс, алба, хэсгүүд “Хөдөлгөөнт эргүүлийн ажлыг зохион байгуулах” хуваарийн дагуу сарын бүрийн 5, 20-ны өдрүүдэд эргүүлийн ажлыг зохион байгуулж, эргүүлийн ажлын талаархи тэмдэглэгээг “эргүүлийн дэвтэрт” хийсэн байна. Эргүүлийн ажлыг “Шивээ-Овоо” сумын Цагдаагийн тасгийн албан хаагч нар болон сумын хариуцлагатай жижүүр эргүүлүүдтэй хамтран ажилласан байна. Говьсүмбэр аймгийн Шивээговь сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлөөс баталсан хуваарийн дагуу 2018 оны 8, 11 дүгээр саруудад хариуцлагатай эргүүлийн ажлыг гүйцэтгэж Говьсүмбэр аймгийн Шивээговь сумын цагдаагийн тасагт эргүүлийн ажил гүйцэтгэсэн талаар танилцуулсан болно.
	Тухай бүр	1.8.Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдэд хариуцлагатай жижүүрийг тухай бүр тушаалаар баталж ажиллуулах	Тус компанийн Гүйцэтгэх захирлын 2018 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн А/24 дүгээр “Хариуцлагатай жижүүрийн хуваарь батлах тухай” тушаал батлан мөрдөн ажиллаж байна. Шивээ-Овоо” ХК нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, уурхайн ажилчдын болон тус сумын нутаг дэвсгэрт үйлдэгдэж болзошгүй гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор 2018 онд - Автобульдозерийн хэсэг

				<ul style="list-style-type: none"> - Уулын нэгдсэн хэсэг - Технологи дамжлагын хэсэг - Цахилгаан хангамжийн хэсэг - Дулаан, ус хангамжийн хэсэг - Засварын хэсэг - Ус шүүрүүлэх хэсэг - Тээвэр үйлчилгээний хэсэгт сар бүрийн 08, <p>20-ны өдрүүдэд 5 доошгүй ажилтнуудын бүрэлдэхүүнтэй эргүүлэн баг гарган, эргүүлийн ажлыг оройн 22:00 цагаас шөнийн 24:00 цагийн хооронд хийхээр эргүүлийн хуваарь гарган, харъяа хэсгийн даргад танилцуулан, гарын үсэг зуруулан баталгаалж, хэсгүүдэд тараан мөрдөн ажиллаж байна.</p>
2.	Архидан согтуурахын эсрэг авах арга хэмжээний хүрээнд	Байнга	2.1. Архидан согтуурахтай тэмцэх олон нийтийн үүсэл санаачлагыг дэмжиж зорилгоор архидалтын эсрэг үйл ажиллагаа явуулдаг, бүлгэм, төрийн бус байгууллагатай хамтарч ажиллах,	Архидан согтуурахтай тэмцэх олон нийтийн үүсэл санаачлалыг дэмжих архидалтыг таслан зогсоох ажлын хүрээнд Говьсүмбэр аймгийн Шивээговь суманд үйл ажиллагаа явуулдаг АА бүлгэмтэй хамтран ажиллахаар болсон болно.
		Тухай бүр	2.2.Компанийн нийт ажилтнууд, тэдний гэр бүлийн гишүүд, компанийн харъяалалын ахмад настан, МШӨ-тэй, групптэй уурхайчдад архины хор хөнөөлийн талаар байнга сурталчилан таниулах.	“Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх” тухай хуулийг сурталчлан таниулах, гэр бүлийн хүрээн дэх ахуйн архидалтыг таслах зогсоох хүрээнд ажилчдад хууль сурталчлах, гэр бүлийн эрх зүйн чиглэлээр сэтгэл зүйчийн тусгайлсан сургалт зохион байгуулах, хууль эрх зүйн мэдлэг эзэмшсэн хууль хүчний байгууллагын албан тушаалтнаар тусгайлсан сургалт зохион байгуулах, хууль сурталчлах самбар байрлуулах, тусгайлсан хууль эрх зүйн чиглэлээр гарсан тараах материал тараах зэргээр сурталчилгааг хийж байна.
		Тухай бүр	2.3.Архидан согтуурахын эсрэг болон нийгмийн дэг журмыг сайжруулахтай холбогдсон төрийн бодлого, хууль тогтоомжийг судлан мэдэж хэрэгжүүлэх.	Монгол Улсын Засгийн газрын 2018.08.22-ны өдрийн 258 дугаар тогтоолын дагуу Захиргаа, хөгжлийн бодлогын хэлтсээс төлөвлөгөө гарган ажиллаж байна. 2018 оны 9 дүгээр сард Монгол Улсын Засгийн газрын 2018.8.22-ны өдрийн 258 дугаар тогтоолын дагуу шалгалтын ажил Говьсүмбэр аймгийн Засаг даргын тамгын газар, Цагдаагийн хэлтэс, Тагнуул, Хууль зүйн хэлтэс, Аудит, Мэргэжлийн хяналтын газрын эрх бүхий албан тушаалтнуудын бүрэлдэхүүнтэйгээр хийгдсэн бөгөөд шалгалтаар

				<p>“Шивээ-Овоо” ХК-ийн удирдлага зохион байгуулалт, авч хэрэгжүүлж буй арга хэмжээ нь хангалттай гэсэн үнэлэлтийг авсан болно.</p> <p>Говьсүмбэр аймгийн Прокурорын газар, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний комиссын Говьсүмбэр аймаг дахь Төлөөлөгчийн газар, Говьсүмбэр аймгийн Цагдаагийн хэлтэстэй хамтарч архидан согтуурахын эсрэг болон нийгмийн дэг журмыг сайжруулах, гэмт хэрэг зөрчлөөс ангид байх, түүнээс урьдчилан сэргийлэх, төрийн бодлого, шинээр батлагдан гарч буй хууль тогтоомжийг компанийн ажилтнуудад сурталчлах ажлыг зохион байгуулж ажиллаа.</p>
		Тухай бүр	<p>2.4.Төрсөн өдөр болон баяр ёслолын арга хэмжээг архигүй тэмдэглэж хэвшихийг өөрөөсөө болон гэр бүлээсээ эхэлж, архинд бусдыг уруу татахгүй байлгаж хэвшүүлэх</p>	<p>Архидалт үндэсний эмгэнэлт үзэгдлийн түвшинд хүрч архидалттай ил болон далд хэлбэрээр тэмцэх, архидалтын түвшинг бууруулах, архидалтгүй хамт олныг бий болгох талаар “Шивээ-Овоо” ХК нь улс, аймаг, сумын эрх бүхий албан тушаалтнуудаас гарч буй шийдвэрийг талархан дэмжиж ирсэн бөгөөд архидалттай тэмцэх, түүнийг таслан зогсоох талаар хатуу байр суурь барин ажилладаг болно.</p> <p>Тус компани нь уул уурхайн олборлолтын үйл ажиллагаа явуулдаг. Ажиллах хүчний 60-70 орчим хувь залуучуудаас бүрдэж байна. Хөдөлмөрийн насны залуучуудыг архи, согтууруулах ундаанаас болж алдаа, эндэгдэл гаргах, гэмт хэрэгт зөрчилд оролцох их байдал тул түүнээс сэргийлэх ажлыг тогтмол зохион байгуулж байна.</p> <p>Архидалттай тэмцэх зорилгоор тусгайлан журам гарган мөрдөн ажиллаж байгаа бөгөөд архи ууж ажлын байранд ирсэн ажилтантай хөдөлмөрийн гэрээ, дотоод журамд заасны дагуу Захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж зохих сахилгын шийтгэлийг ногдуулж байна.</p> <p>Нийт ажилчдын хурал цуглаан дээр төрсөн өдөр, тэмдэглэлт өдрүүдийг архигүй тэмдэглэж хэвших, бусдыг архи, согтууруулах ундаа хэрэглэхэд уруу татахгүй байх уриалга гарган архины хор хөнөөлийн талаар ухуулга хийж байна.</p>
3.	Аймаг, сумын хууль, хяналтын байгууллага, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх	Тухай бүр	<p>3.1.ГХУС тухай хууль, ЗГ-ын 2012.07.25-ны 252 дугаар тогтоолоор батлагдсан “Хөтөлбөр”-ийн хүрээнд дэх шаардлагатай мэдээ мэдээллийг хуулийн зөвлөх сар бүр авч байх.</p>	<p>Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн 252 дугаар тогтоолоор батлан гаргасан “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэдээлэл, сурталчилгааны хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх зорилгоор компанийн дотооддоо мөрдөхөөр гаргаж буй эрх зүйн баримт бичиг болох дүрэм, журам, тушаал, шийдвэрт тусган ажиллаж байна.</p> <p>Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийг хэрэгжүүлэх түүний хүрээнд УИХ, ЗГ-аас баталж буй хууль, дүрэм журмыг ажилтнуудад сургалт хэлбэрээр зохион байгуулж эрх зүйн мэдлэгийг дээшлүүлж</p>

ажлыг зохицуулах зөвлөлтэй хамтран ажиллах хүрээнд			байна. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 4-д заасан “Хууль, Улсын Их хурлын бусад шийдвэрийг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлэхдээ “Төрийн мэдээлэл” эмхэтгэлд нийтэлсэн албан ёсны эхийг баримтлах бөгөөд дамжуулан нийтэлснийг албан ёсны бус гэж үзнэ” хэмээн заасны дагуу компани “Төрийн мэдээлэл” эмхэтгэлд нийтэлсэн хууль, дүрэм, журам, шийдвэрийн мэдээллийг авч ажиллаж байна.
	Тухай бүр	3.2. Удаа дараа архидан согтуурч сахилгын шийтгэл хүлээсэн, архины хамааралтай ажилчдыг шаардлагатай гэж үзвэл Согтуурах, мансуурах донтой өвчтэй этгээдийг захиргааны журмаар албадан эмчлэх, албадан хөдөлмөрлүүлэх тухай хуульд зааснаар албадан эмчилгээнд явуулах талаар сум, багийн Засаг дарга, цагдаагийн хэсэгт санал оруулах	Архидан согтуурч нийгмийн хэв журам зөрчсөн, зөрчсөний улмаас цагдаагийн байгууллагаас эрүүлжүүлэгдсэн болон орон байрандаа архидан согтуурч олон нийтийн амгалан тайван байдал алдагдуулсан ажилчдын нэрсийг “Шивээговь сумын цагдаагийн тасаг”-тай хамтран гаргасан болно. Дээрх ажилчдад Говьсүмбэр аймгийн Цагдаагийн хэлтэстэй хамтран “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль” “Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль” “Эрүүгийн хууль”-ийг сурталчлан таниулах талаар сургалт тусгайлан 2018.06.20-ны өдөр зохион байгууллаа. Согтуурах, мансуурах донтой өвчтэй этгээдийг захиргааны журмаар албадан эмчлэх, албадан хөдөлмөрлүүлэх тухай хуулийн дагуу албадан эмчилгээнд явуулахаар сум багийн засаг дарга, цагдаагийн тасагт хүсэлт гаргасан тохиолдол 2018 онд байхгүй болно.
	Байнга	3.3. Аймаг, сумын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын зохицуулах зөвлөлтэй хамтран ажиллах	2018 оны жилийн эцсийн байдлаар сумын “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл”-ийн хуралд тус компанийн хуулийн зөвлөх нийт 3 удаа оролцож, 2018 оны сумын “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөө”-г батлах, Говьсүмбэр аймгийн Прокурорын газраас Шивээговь сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөл, Иргэдийн төлөөлөгчдийн хуралд ирүүлсэн мэдэгдлийн дагуу хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах хуралд тус тус оролцсон байна. Мөн Сумын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлөөс ирүүлсэн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд архины хор хөнөөл, бусад шинээр батлагдсан хуулийн хүрээнд урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт зохион байгууллахаар ирүүлсэн мэдэгдлийг биелүүлэн ажилласан байна.

		Тухай бүр	3.4. Хууль, хяналтын байгууллагаас ирсэн бичиг, авах арга хэмжээний тухай ажлыг зохион байгуулж, хариуг тогтмол өгч байх.	<p>2018 оны жилийн эцсийн байдлаар тус компанид хууль хяналтын байгууллагаас гэмт хэрэг зөрчилд холбогдсон болон зөрчил арилгуулах талаар 2 мэдэгдэл ирүүлснийг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2-д зааснаар хариуг хугацаанд нь өгч ажилласан.</p> <p>Шивээговь сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн 2018.05.25-ны өдрийн 1/124 дүгээр албан бичгийн дагуу “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх” тухай хуулийг сурталчлах ажилчдад таниулах ажиллагааг хийж 2018.06.08-ны өдрийн 1/597 дугаар албан бичгээр хариуг өгсөн болно.</p> <p>Говьсүмбэр аймгийн Прокурорын газрын 2018.07.09-ны өдрийн Б/33 дугаар “Гэмт хэрэг гарсан шалтгаан нөхцлийг арилгуулах тухай” мэдэгдэл ирсэн бөгөөд мэдэгдлийн хариуг 2018.08.07-ны өдөр хүргүүлсэн болно.</p> <p>Говьсүмбэр аймгийн Прокурорын газрын 2018.10.11-ний өдрийн 13/45 дугаар “Гэмт хэрэг гарахад нөлөөлсөн шалтгаан нөхцөлийг арилгуулах тухай” мэдэгдэл ирсэн бөгөөд мэдэгдлийн хариуг 2018.11.06-ны өдрийн 1/935 дугаар албан бичгээр тус тус хүргүүлсэн болно.</p>
4.	Сургалт, сурталчилгаа, олон нийтэд чиглэсэн ажлын хүрээнд	байнга	4.1. Компанийн хэмжээнд гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд аливаа хийсэн ажлыг тухай бүр компанийн цахим хуудас, мэдээллийн самбарт байршуулах	<p>Компанийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд хийгдсэн ажлыг тухай бүр “Шивээ-Овоо” ХК-ийн цахим хуудсанд байршуулан ажиллаж байна.</p> <p>Гэр бүл нийгмийн анхдагч үндэс суурь түүнийг бэхжүүлэх, хүчирхийлэл түүнээс улбаалан гарах гэмт хэрэг, зөрчлөөс ангид байлгах ажлын хүрээнд хийгдсэн сургалтын талаарх мэдээлэл, компаниас зохион байгуулж буй ажлын талаарх мэдээллийг фэйсбүүк, цахим орчноор сурталчлан ажиллаа.</p> <p>Компанийн ХАБЭА-н дүрэм, журмыг сайжруулах, шинэчлэх, хэрэгжилтийг хангуулах зорилгоор үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд мөрдөгдөх нийтлэг дүрэм, журмыг боловсруулан сайжруулж батлуулан нийт ажилтнуудад тараасан.</p> <p>Компанийн ажилтнуудын нийтээр дагаж мөрдөх /ХАБЭА-н талаарх/ 9 журам, зааврыг энгэрийн ном, гарын авлага болгон хэвлэж бүх ажилтнуудад тарааж, ээлжит давтан зааварчилгаа өгч журмыг танилцуулсан.</p>
		Байнга	4.2. Спорт заалыг тогтмол ажиллуулж, хувиар гарган хэлтэс, хэсэг, албаны ажилтнуудын чөлөөт цагийг зөв боловсон	<p>Ажилтнуудынхаа чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор спорт заалны ажиллах цагийн хуваарийг нэмэгдүүлж хэлтэс, хэсгүүдийг хуваарийн дагуу тоглуулан хэвшсэн.</p> <p>“Шивээ-Овоо” ХК нь Хаялга спорт клубын үйл ажиллагааг уурхайчдын бие бялдар болон сум орон нутгийн иргэд, хүүхдүүдийн зөв боловсон</p>

		өнгөрүүлэх	цагаа өнгөрөөх, гэмт хэрэг зөрчлөөс хүүхдүүдийг ангид байлгах үүднээс секц дугуйланг идэвхтэй явуулж байна. Хаялга спорт клуб нь <ul style="list-style-type: none"> - Гар бөмбөг - Сагсан бөмбөг - Хөл бөмбөг - Бокс - Жудо бөх - Дарц Шатар, даам гэсэн 7 төрлийн секц дугуйланг долоон хоногийн 6 өдөр тасралтгүй явуулж ажилчид болон хүүхдүүдийн ирээдүйн амьдралд бие бялдар оюун санааны суурь төлөвшлийг бий болгох зорилт тавин ажиллаж байна. Хүний хөгжлийг дэмжих ажлын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу 2018 онд ажилтнуудынхаа дунд спорт, урлагын томоохон арга хэмжээ зохион байгуулаад байна. <ul style="list-style-type: none"> - Уурхайн хэлтэс, алба, хэсгийн хүрээнд спорт, урлагын нэгдсэн өдөрлөг, аст тэмцээн, зохион байгуулсан.
	2018 оны 10 дугаар сард	4.3. Сурагчдын дунд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сэдвээр дэвжээ тэмцээнийг зохион байгуулах	2018 оны 10 дугаар сард “Сурагчдын дунд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сэдвээр дэвжээ тэмцээн зохиох” ажил төсвийн зардал хүрэлцээгүйн улмаас 2019 онд зохион байгуулагдахаар хойшлогдсон. “Шивээ-Овоо” ХК нь Хэлтэс, алба, хэсэг, нэгжүүдийн ажилтнуудыг гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд жил бүр “Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн” хуулийг сурталчлах, эрүүл аюулгүй хамт олныг бий болгох, осол аваараас урьдчилан сэргийлэх хууль, дүрмийг сурталчлах, ажилчдын хууль, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээр “ХАБЭА-н” аст тэмцээнийг компанийн хэсэг, алба, хэсэг, нэгжийн ажилчдын дунд зохион байгууллаа. Тэмцээнд дараахь хууль, дүрэм, журмыг сурталчлан таниулах ажлыг хийсэн болно. <ul style="list-style-type: none"> - Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль - Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх дүрэм - Хөдөлмөрийн тухай хууль - Компанийн хөдөлмөрийн эрүүл аюулгүй байдал, эрүүл ахуйн менежментийн нэгдсэн систем - Ил уурхайн аюулгүй ажиллагааны дүрэм - Ажлын байранд осолдогсдод үзүүлэх эмнэлгийн анхан шатны тусламж гэх мэт Хөдөлмөрийн аюулгүй байдалтай холбоотой бусад хууль, дүрэм

				<p>журмын хэмжээнд “Шивээ-Овоо” ХК-ийн бүх хэсэг, алба, хэсэг, нэгжийн ажилчдын 10 доошгүй хүний бүрэлдэхүүнтэй 6 баг өрсөлдөж өөрсдийн хууль зүйн мэдлэг боловсролоо сорин өрсөлдсөн болно.</p> <p>Уг аст тэмцээнд уурхайн 60 гаруй ажилтан тэмцээнд оролцсон. 200 гаруй ажилтан албан хаагч, тэдгээрийн гэр бүлийн гишүүд орон нутгийн иргэд үзэн сонирхож, Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн хууль, дүрэм, журмын мэдлэгээ дээшлүүлсэн байна.</p>
5.	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх идэвхи санаачлагыг дэмжих, урамшуулах ажлын хүрээнд	Тухай бүр	5.1. Тухай бүрт Компанийн төлөвлөгөөг харгалзан төсөв батлаж хэрэгжүүлэх	Тус компани “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил”-ын хүрээнд 2018 оны Бизнес төлөвлөгөөнд тусган төсөв батлан ажиллаж байна.
		2018 оны 12-р сард	5.2. Оны турш гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд идэвхитэй хамрагдсан хэлтэс, алба, хэсгүүдийн урамшуулах.	Нийт ажилтан, хэсэг, нэгжүүдийн дунд ХАБЭА-н дүрэм журам, зааврын мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор “АСТ”-ийг зохион байгуулсан. “АСТ” тэмцээнд байгууллагын нийт 5 хэлтэс, 3 алба, 8 хэсэг нэгжийн ажилтнууд хамрагдаж Технологи дамжлагын хэсгийн баг, хамт олон түрүүлж “Шилдэг хамт олон” болж шагнуулсан.
ШОХК				